

ТАНИЛЦУУЛГА

*Засгийн газрын болон Монголбанкны
үнэт цаас худалдан авах хөрөнгийн
хэмжээг батлах тухай*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас худалдан авахад хөрөнгө оруулж болно гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 13.1.1, 13.1.2-т заасан үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж тус тус заасан.

Мөн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсан.

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” тогтоолын төслийг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг авахаар хүргүүлсэн.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ